



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2005 оны 3 сарын 2 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

**Нийслэлийн өмчит үйлдвэрийн
газрыг татан буулгах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дүгээр заалт, Нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

Нэг. Өөрийн ажлын байргүй, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай, техник технологийн хоцрогдолд орсноос үр ашиггүй ажиллаж байгаа өнгөт гэрэл зургийн “Агфа” төвийг татан буулгахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М. Энхболдод зөвшөөрсүгэй.

Хоёр. “Агфа” төвийн өрийн асуудлыг барагдуулах тухай санал боловсруулж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М. Энхболдод үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН ДАРГА

Болормаа

Н. БОЛОРМАА

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Билэгт

Т. БИЛЭГТ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД:

Ш. Алтангэрэл
Я. Аюушжав
Д. Баасансүрэн
С. Баярмөнх
Г. Мөнхбаяр
С. Отгонбат
Б. Ундармаа

Ш.АЛТАНГЭРЭЛ
Я.АЮУШЖАВ
Д.БААСАНСҮРЭН
С.БАЯРМӨНХ
Г.МӨНХБАЯР
С.ОТГОНБАТ
Б.УНДАРМАА